

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Огноо: 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2022 оны буюу 17 дугаар уян хатан нэгтгэл тайлан боловсруулах**

Тендер шалгаруулалтын дугаар: **УУХҮЯ/202312012**

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь 2023 онд Улсын төсвийн хөрөнгөөр, ОУИТБС-ын төслийн хүрээнд “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2022 оны буюу 17 дугаар уян хатан нэгтгэл тайлан боловсруулах”-ыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын стандартын дагуу тайланг бэлтгэх, сонгогдсон компаниудын тайланг тулган баталгаажуулах, англи хэл дээрх орчуулгыг боловсруулах бөгөөд мэдүүлгээ ирүүлж буй хуулийн этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах материалуудыг баталгаажуулж ирүүлнэ. Үүнд:
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар
 - Байгууллагын дэлгэрэнгүй танилцуулга
 - Татварын цахим тодорхойлолт
 - Нийгмийн даатгалын өргүй тухай тодорхойлолт
 - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт
 - Шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа
 - Санхүүгийн чадавхын мэдээлэл 2021, 2022 онуудын аудит хийгдсэн санхүүгийн тайлан
 - Сүүлийн 2 жил /2021, 2022/ ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /жагсаалт/
 - Зөвлөх хуулийн этгээдийн хүний нөөцийн чадавхын талаарх мэдээлэл /жагсаалт, CV/ болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт) ирүүлнэ.

Ажлыг богино хугацаанд чанартай гүйцэтгэх зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцох боломжтой эсэх: Зөвшөөрнө.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2023 оны 04-р сарын 14-ний өдрийн 18 цаг 00 минут хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр 2023 оны 04-р сарын 24-ний өдрийн 11 цаг 00 минутын дотор ирүүлнэ үү.

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын алба,
Пиис Билдинг оффис, 205 тоот өрөө, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Улаанбаатар хот, 210640а, Монгол Улс
Утас: 70110525, Факс: 70110155
Цахим шуудан: admin@eitimongolia.mn
Цахим хуудас: www.eitimongolia.mn